



ТӨВ АЙМГИЙН  
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН  
ГАЗАР

41100 Зуунмод, Төв аймаг  
Утас: 70273539 . Факс: 70273579

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

2020.03.02 № 35  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Нээлтийг хойшлуулах тухай

“Шинэ коронавирусын эрсдлээс урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангах тухай” Төв аймгийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/124 дугаар захирамжид 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 08:00 цаг хүртэл хугацаанд аймаг хүртэл зорчих хөдөлгөөнд хязгаарлалт хийсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т зааснаар “Тендер нээхэд тендер оролцогч, эсхүл түүний төлөөлөгч болон сонирхсон бусад этгээд оролцох эрхтэй” бөгөөд хөдөлгөөнийг хязгаарлалт хийсэн нь Төв аймгийн Зуунмод суманд тендерийн нээлт хийхэд тендер оролцогчдийн нээлтэд оролцох эрхийг хязгаарласан гэж үзэж болохоор байна.

Иймд араах нэр, дугаар бүхий тендерийн нээлтийг 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдөр болгон хойшлуулж байна.

- ТӨАОНӨГ/202012017, Аймгийн нэгдсэн эмнэлгийн эрчимт эмчилгээний тасагт хяналтын монитор худалдан авах
- ТӨАОНӨГ/202012020, Аймгийн Нэгдсэн эмнэлэгт унтуулгын аппарат, тоног төхөөрөмж худалдан авах

Тендерийн нээлттэй холбоотойгоор тендерийн баталгааны хугацаанд өөрчлөлт оруулж байгааг анхаарч, үйл ажиллагаагаа зохион байгуулна уу.

Хавсралт 2 хуудастай.

ДАРГА  Д. БАТЖАРГАЛ

202040018



МОНГОЛ УЛС  
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/24

Зуунмод

Шинэ коронавирусийн эрсдэлээс  
урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн  
байдлыг хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.1 дэхь заалт, 24 дүгээр зүйлийн 24.1 дэхь заалт, 32 дугаар зүйл 32.1.1 дэхь заалт, 33.3 дахь заалт, Улсын онцгой комиссын 2020 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 02 дугаар тогтоол, 7 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумдын Засаг дарга нарт ДААЛГАХ нь:

1.1. Аймаг, сум хооронд зорчих хөдөлгөөнд 2020 оны 02 дугаар сарын 27-ны 08:00 цагаас 2020 оны 03 дугаар сарын 03-ны 08:00 цаг хүртэлх хугацаанд хязгаарлалт хийх.

1.2. Хяналтын цэгт ажиллах алба хаагчдыг удирдлагаар ханган, хүндэтгэн үзэх шалтгааны улмаас (ар гэрийн гачигдал, эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээ, албан томилолт) аймаг, сум хооронд зорчих төрийн албан хаагч болон иргэдийн нотлох баримтыг үндэслэн хүндрэл чирэгдэл учруулахгүйгээр нэвтрүүлэх арга хэмжээ тухай бүр авч ажиллах.

1.3. Улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан Төрийн алба хаагчдыг гадаад орон руу албан томилолтоор зорчихыг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс 03 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд хориглох арга хэмжээ авах.

1.4. Бүгд Найрамдах Солонгос Улс болон коронавирусийн халдвар илэрсэн улс орноос тухайн сумын нутаг дэвсгэрт ирсэн иргэдийн хөдөлгөөнд хяналт тавих.

2. Эрүүл мэндийн газрын дарга С.Мөнхтуяад ДААЛГАХ нь:

2.1. Коронвирусийн халдвараас урьдчилсан сэргийлэх бэлтгэл бэлэн байдлыг хангах зорилгоор эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, халдваргүйтгэлийн бодисын нэмэлт нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулах.

3. Аймгийн Засаг даргын орлогч Д.Мөнхбаатарт ДААЛГАХ нь:

3.1. Сумдад төвлөрсөн дулааны станцуудын нүүрсний нөөц дутагдаж байгаатай холбогдуулан нүүрс таталтын ажлыг зохион байгуулах, /тээвэрлэгч байгууллага, тээврийн хэрэгслийн марк, улсын дугаар зэрэг мэдээллийг жагсаалаар гаргаж постуудад хүргүүлэх/ хяналтын цэгүүдээр нэвтрэх нөхцөл боломжийг бүрдүүлэх.

3.2. Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд хүнсний гэл нэрийн бүтээгдэхүүний хангамж, хүрэлцээг тогтвортой байлгах, нөөц бүрдүүлэлт, тээвэрлэлтийг зохион байгуулах.

01 00303

4. Тагнуулын хэлтсийн дарга, дэд хурандаа Л. Энхбаатар ДААЛГАХ нь:

4.1. Уламжлалт болон уламжлалт бус шашны байгууллагууд зөвхөн дотооддоо хурал, ном хурах талаар албан ёсны заавар зөвлөмж хүргүүлж, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулдаг газруудыг таслан зогсоох.

4.2. Иргэд, олон нийтийг оролцуулсан хурал цуглаан, зохион байгуулалттай болон олон хүн төвлөрсөн аливаа шашины зан үйл зэрэг арга хэмжээг зохион байгуулахгүй байх талаар хяналт тавьж ажиллах.


5. Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын дарга Д.Батцэцэг, Мэргэжлийн хяналтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Энхтуяа, Ар жанчивлан рашаан сувилалын гүйцэтгэх захирал Б.Ундрах нарт даалгах нь:

5.1. Шинэ коронавирусийн халдвар гарсан улс оронд оршин сууж байсан, дамжин өнгөрсөн, халдвартай хүнтэй болон сэжиг бүхий хүнтэй хавьтал болсон /хамт байсан, нэг унаанд суусан зэрэг/ өгүүлэмжтэй хүмүүсийг тусгаарлах байрыг Ахмадын амралт сувилалын газар, Ар Жанчивлан рашаан сувилал зэрэг газруудад байгуулж тухайн иргэдийг 14 хоногийн хугацаанд өөрсдийнх нь зардлаар тусгаарлах.

5.2. Тусгаарлах байрны ердийн стандартын дагуу тоноглох, халдвар хамгаалалыг тогтмол хийлгүүлэх, хяналт тавьж ажиллах.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ч.Сарангэрэл/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.БАТЖАРГАЛ